

**Монголын түүхийн талаарх олон улсын судалгаа:
Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн
Монголын түүх**

Доктор /Sc/, профессор Удо Б. Баркманн /ХБНГУ/

1988 оны 11 сарын 16-ны өдрийн “Үнэн” сонины дугаарт тухайн үедээ байнгын үзэгдэл байсан улс төрийн тогтоолын нэгэн төсөл хэвлэгдэхэд “Намын зохион байгуулалт, эрх баригч намын үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай” гэсэн уриалга, сулхан гарчиг бүхий сэдвийг уншигчид сурсан зангаараа хайнгадуу гүйлгэн хараад л өнгөрсөн байхаа.

Тэр үеийн сонин уншигчид сонины иймэрхүү өгүүллийг унших өөрийн гэсэн “өвөрмөц” аргатай байсан ба энэ нь Зүүн Берлин, Москва, Улаанбаатарын аль ч алинд түгээмэл байлаа.

Энэ нь дээрх улсын улс төрийн материалд ховорхон өртөгддөг содон үг хэллэгийг л хайх явдал байсан юм. Ийм содон үг хэллэг дээр уншигчийн нүд тусмагц тухайн мөрүүдийг анхааралтай уншдаг байв.

1988 оны 11 сарын 16-ны сонины нэгэн дугаарт “Гучаад оны үеийн хувьсгалын зүй тогтоолын ноцтой гажуудал”, “Х.Чойбалсанг тахин шүтэж байсан нь” гэсэн гарчгийг уншигчид олж хараад мэл гайхсан буй заа.

“Манайд гучаад оноос хувьсгалт хууль ёсыг ноцтой завхруулж таслан улмаар нэг хүнийг, тухайлбал, Х.Чойбалсанг тахин шүтэх явдал газар авснаас нам, төр, цэрэг, аж ахуй, соёлын боловсон хүчин, ард иргэд, жирийн лам, хувраг сүсэгтнийг олноор хэлмэгдүүлж, хувьсгалын эсэргүү хүчний үүр голомт болсон гэдэг нэрээр сүм хийдийг нураан соёлын өвийг үрэн таран хийсэн гунигт явдал гарчээ”¹.

Үүгээр МАХН-ын удирдлага БНМАУ-ын түүхийн талаарх хэлэлцүүлэг маргааныг нээсэн юм.

Түүхчид уг ажлыг дуртайяа гардан авав. Архивуудын сан хөмрөгийг харьцангуй чөлөөтэй ашиглах боломж нээгдэж, хуучин үзэл суртлын номлол болон зөвлөлтийн түүхийн шинжлэх ухааны зааварчлага унасан нь ахар хугацааны дотор түүхийн судлалд урьд өмнө байгаагүй ахиц гаргав. Түүхчид судалгааны тэргүүн зэргийн зорилтуудаа даруй тодорхойлов.

1. Сталины харгислалын жилүүдэд болон тухайн үед холбогдох улс төрийн зүтгэлтнүүдийн намтрын судалгаа,

2. Монголын үндэсний төрийн түүхийн судалгаа зэрэг асуудал чухалчлагдах болжээ. Үүний улмаас гол нийтлэлүүд юуны өмнө 1911-1945 оны зурвас үеийг хамрах болсон бөгөөд 1945-1990 оны үеийн улсын түүхийн асуудал бараг тусгагдсангүй. Монголчууд өвөг дээдсийнхээ үүх түүхийн талаар мэдэх ихээхэн эрмэлзлэлтэй байсан боловч “Чингис хаан”, “Монголын нууц товчоо”, “Монголын их гүрэн” зэрэг сэдвээрх судалгааны 1991 оны үеийн ахархан цэцэглэлт тэгэхийгээд л намжив.

Гагцхүү Ш.Нацагдорж энэ чиглэлээрх судалгааг тасралтгүй хийж 1991 онд Чингис хааны намтар, дараа нь 1998 онд Хубилай хааны намтрыг бичсэн байна.²

Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг 1962 онд тэмдэглэх үеэр түүнийг Монголын үндэсний баатар болгон тунхагласнаар судалгааны энэ чиглэл

¹ Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай, Үнэн, 1988.11.16.

² Ш. Нацагдорж, Чингис хааны цадиг, Улаанбаатар 1991; Хубилай Хаан, Улаанбаатар 1998.

нь Москвагийн шахалтын дор улс төрийн хяналтанд орж, ингэснээрээ Монголын эртний үеийн түүхийн судалгааг орхигдуулан зогсооход хүргэсэн билээ. Чингис хааны судлал бүх монголчуудын голомт болсон Монгол улсад одоо болтол төдийлөн хүч аваагүй байна.

Үүнтэй холбогдуулан Ерөнхийлөгч Н.Багабандийн зарлиг Чингис хааны төрсөн өдөр болон Монголын их гүрэн үндэслэн байгуулагдсан ойг улсын их баяр болгож, мөн энэ чиглэлийн судалгаанд зохих түлхэц үзүүлэх боломж нээгдэж байна.

1990 оноос хойш хэвлэгдсэн түүхэн нийтлэлүүдийг базаж үзвэл тооны хувьд үлэмж ихээхэн нь намтар судлалд холбогдож буй нь харагдаж байна. Намтрын дийлэнх судалгаанууд 1937-1938 оны үеэр Сталины харгислалд өртөж амь үрэгдсэн гарамгай зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг сэргээн тодруулах судалгааны ажлын үр дүн болно.

С.Идшинноров, Л.Бат-Очир, Ж.Болдбаатар зэрэг тэргүүлэгч түүхч-эрдэмтдийн зэрэгцээгээр О.Батсайхан нарын залуу түүхчид ч уг зорилтыг шийдвэрлэхэд оролцож ирэв. Намтар судлалын зонхилох хэсэг нь юуны өмнө, хэлмэгдэгчдийн намтар гэгч сэдэвт хамрагдах боловч тэдгээр “хэлмэгдэгч”-ийг түүхэн цаг үеийн цар хүрээнээс нь ажиглавал бас ч “хэлмэгдүүлэгчид” ч гэж болохоор улс төрийн зүтгэлтнүүд юм.

Харин шарын шашны хутагт хувилгаадын үйл амьдралд холбогдох нийтлэл нь хэлмэгдэгчдийн намтар судлалын хамгийн бага хувийг эзэлж байгаа ба 1990 оноос хойш хуучин Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны архиваас багахан хэмжээний материал хэвлүүлжээ.

Эрдэмтэн түүхч Л.Бат-Очирын бичсэн “Чойбалсангийн намтар”³ нь онцгойлон дурдвал зохих бүтээл бөгөөд Монголын намтар бичлэгийн томоохон хэмжээний зохиол гарцаагүй мөн.

Түүхчид ерөнхий сайд асан А.Амар, П.Гэндэн зэрэг зүтгэлтнүүдийн намтрын судалгаа хийх явцдаа Монгол улсын улс төрийн амьдралд ЗХУ-н оролцолгооны асуудлыг хөндөн үзсэн юм. Тийм ч учраас хуучин ЗХУ-ын архивуудын материал Монголын түүх судлалын ажилд амин чухал ач холбогдолтой байв. Энэ талаарх монголын түүхчдийн эрдэм шинжилгээний ажил зохих үр дүнд хүрч байна.

Эрээд оны эхний хагаст архив нээлттэй болсны үр дүнд өргөн цар хүрээтэй түүхийн баримт мэдээллийн хуримтлал богинохон хугацааны дотор буй болсон бөгөөд энэ нь монголын улс төрийн түүхийн талаар урьд өмнө хийгдсэн омтгой үнэлэлт дүгнэлтүүдийг дахин сайтар хянан үзэх боломж, шаардлагыг бүрдүүлжээ.

Монголын түүхчдийн бүтээл нь олон улсын монголын түүх судлалд шийдвэрлэх биш юмаа гэхэд чухал түлхэц үзүүлсээр байна. Энэхүү хураамжлан өгүүлж буй зүйл бол монголын түүхийн талаар олон улс дахь, тэгэхдээ үүнд юуны өмнө монгол судлалын төвүүдтэй улс орнуудад 90-ээд онуудад хийгдсэн судалгааны өнөөгийн байдлыг дэлгэн харуулах хэрэгцээ шаардлагыг хангалттай харуулж байна.

Үүнтэй уялдуулан уг судалгааны хандлага чиглэл зарим үр дүнгийн талаар доор товч сийрүүлэн толилуулъя:

Орос улс дахь монголын судлал монголын түүх судлалд урьдын адил тэргүүлэх үүргийг гүйцэтгэсээр байгааг хэн хүн мэтгэн маргахгүй бизээ. Тэндхийн олон үеийн эрдэм шинжилгээний ажлын уламжлал, оросын зүгээс

³ Л.Бат-Очир, “Чойбалсан”, Улаанбаатар, 1996 он.

монголыг геополитикийн учир холбогдлын үүднээс сонирхон олгож буй зардал болон орос орон Халимаг, Буриад угсаатнуудыг нэгтгэн байдгийн хувьд монголчуудын хэл, соёл, түүх судлалд үлэмж ойр холбоо харилцаатай байдгийг ч аваад үзсэн монгол судлалын эрдэм шинжилгээний ажил үлэмжхэн боломжоор хангагдаж байдаг. Оросын монголч эрдэмтдийн монголын түүхийн судалгаа улс төрд зөвлөгч үүрэг болон гадаад улс төрийн бодлогод холбогдох дүгнэлт өгөхөд анхаарлаа хандуулдаг.

Монголын асуудлаарх оросын экспертүүд монголын улс төрийн түүхийн өвөрмөц онцлогийг сайтар мэдэх юм. Тэд ерээд оны эхэн үед монголд явагдсан түүхийн хэлэлцүүлэг хийгээд монгол-оросын харилцаанд түүний үзүүлэх үйлчилгээ нөлөөллийг гярхай ажиглаж байв. Харин тэд ерээд оны дунд үеэс хойш монголын улс төрийн түүхийн асуудлаарх шинжилгээ дүгнэлтээ нийтэлж эхэлсэн нь үндсэндээ доорх 2 хүчин зүйлсээс шалтгаалсан болов уу гэж бодож байна.

1. Оросын монголч эрдэмтэд ерээд оны эхэн үеэс л хуучин ЗХУ-ын архивын материалтай танилцах боломжтой болсон.
2. Одоогийн Орос улсын зүгээс хуучин ЗХУ-ын үед монголтой харьцаж байсан улс төрийн бодлогоо эргэн харж, зарим зүйлийг тодруулах шаардлагатай болсон.

Үүнтэй нягт уялдаатайгаар хоёр улсын ерөнхийлөгч Б.Ельцин, П.Очирбат нар 1993 оны дээд хэмжээний уулзалтынхаа үеэр Оросын талд маш ашигтай баримт бичигт гарын үсэг зурсан юм. Үүнд: "Хуучин ЗСБНХУ, БНМАУ-д гучаас дөчөөд онд гэм буруугүй олон хүний амь насыг бүрэлгэн, хоёр орны ард түмэнд сэтгэл санааны болон эд материалын асар хохирол учруулж, үй олноор нь хоморголон хэлмэгдүүлж байсанд хоёр улсын ерөнхийлөгч гүнээ харамсаж байна. БНМАУ-д энэхүү хэлмэгдүүлэлт нь тэр үеийн зөвлөлтийн удирдагчид, коминтерны шууд даралт шахалтаар эхэлж, түүнд зөвлөлтийн сургагч, зөвлөхүүд оролцож байсныг баримт, хэрэглэгдэхүүн гэрчилж байна. Үүний хариуцлага өнөөгийн орос улсад холбогдолгүй юм."⁴ гэжээ.

Монголын түүхийг судалж боловсруулах ажилд оросын шинжлэх ухааны академийн дорно дахины судлалын хүрээлэнгийн монголын тасгийн эрдэм шинжилгээний ажилтнууд гол үүрэг гүйцэтгэж байна. Тэд үндсэндээ гадаад монголын буюу хожмын БНМАУ-ын түүхийн асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Харин өвөр монголын түүхийн асуудлаар, жишээлбэл, угсаа гарвал, хэл, соёл нэгтэй буриадууд судалгаа хийх талаар давуу талтай боловч, энэ талаар хийсэн судалгааны зүйл бараг алга байна. Монголын түүхийн судалгаанд дараах гурван асуудлыг онцгойлон үзэж болно.

1. Монголын түүхийн талаар монголд хэвлэгдэж буй нийтлэлүүдийг анхааралтай ажиглан, хянан дүгнэж байна. Тухайлбал түүхч Ш.Бира, В. Ширэндэв, С. Идшинноров, Л. Бат-Очир нарын хянасан нийтлэгч Б. Баабарын товч найруулал болох "ХХ зууны монгол - нүүдэл суудал"⁵ бүтээлийг Роцин, Гуревич нар шүүмжлэлтэйгээр үнэлэн дүгнэсэн.⁶

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгч, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын хамтарсан мэдээгдэл, Ардын Эрх, 1993.01.22.

⁵ Баабар, ХХ зууны монгол - нүүдэл суудал, Улаанбаатар 1996 он.

⁶ С. Роцин, Проблемы Дальнего Востока 6(1998), 143-146; В. Gurevich, Far Eastern Affairs 1992, 124-130-р тал.

2. Бусад улс орнуудад дахь монгол судлалын төвүүдийн түүхийн судалгааг ажиглан харж байна.⁷
3. Оросын монголч эрдэмтэд судалгааныхаа чадавх туршлагаар монголын түүхийн үеүдийг бүхэлд нь хамарч, монголын улс төрийн түүхийг хэрхэн авч үзвэл зохих үндсэн баримтлалын асуудлаар ч хэлэлцүүлэг маргаан өрнүүлж чадах боломжтой юм. Үүнтэй уялдуулан энд "Алс дорнодын хэрэг явдал" сэтгүүлд нийтлэгдсэн "Монгол улсын 70 жил" сэдэвт дугуй ширээний ярилцлага⁸ болон "Восток" сэтгүүлд Грайворонский, Яскина, Роцин, Гольман, Железняков нарын нийтлүүлсэн материалыг дурдмаар байна.

Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд монголын түүхэнд холбогдох шинэ үеийнхээ судалгааг 1994 оноос хойш эн тэргүүнд "Восток", "Проблемы Дальнего Востока", "Far Eastern Affairs" зэрэг мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтэлж эхэлсэн юм.

Эдгээрээс нэгтгэн ажиглахад судалгаа шинжилгээний дараах гурван чиглэл ялгарч байна:

1. Монгол дахь Коминтерны үйл ажиллагаа

Эл судалгааны асуудал хоёр салбар асуудлыг хамаардаг:

А. Монгол дахь Коминтерны үйл ажиллагааг дангаар авч үзэх

Б. Монголыг Хятад дахь Коминтерны үйл ажиллагааны түшиц болгон авч үзэх,

Оросын Шинжлэх Ухааны Академийн Алс Дорнодын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн "ВКП(б), Коминтерн и Национально-революционное движение в Китае" хэмээх баримт бичгийн эмхтгэл⁹ нь Монгол дахь Коминтерны үйл ажиллагааг судлахад хүчтэй түлхэц үзүүлсэн бөгөөд "Коминтерн ба Монгол" хэмээх баримт бичгийн чухал нэгэн түүвэр гарахын шууд угтал болсон юм. "Дальневосточная политика Советской России (1920-1922гг.), Сборник документов Сибирского революционного комитета" хэмээх баримт бичгийн түүвэр эдгээр баримт бичгийн эмхэтгэлүүдийг улам бүр баяжуулан дэлгэрүүлж байгаа юм.

С. Роцин, Г. Адибеков нар Монгол улс дахь Коминтерны үйл ажиллагааны талаар хэд хэдэн өгүүлэл бичжээ. С. Роцин өгүүлэхдээ Тугар Рыскулов, М. И. Амгаев¹⁰ зэрэг монголд ажиллаж байсан коминтерны төлөөлөгчдийн ажиллагааны талаар авч үзсэн бол Г. Адибеков коминтерны гүйцэтгэх хороо, МАХН-ын удирдлага хоёрын харилцааны асуудлыг нягталж үзжээ.¹¹

Улаан-Үдэд хэвлэгдсэн бас нэгэн баримт бичгийн түүвэрт Коминтерны идэвхтэн болох Элбэгдорж Ринчино-гийн үйл амьдралд холбогдох чухал баримтууд оржээ.¹² Энэ эмхэтгэлд орсон баримт бичгүүд Монголын

⁷ М. И. Гольман, *Монголоведение в КНР*, Восток 6(1991), 143-144; *Монголоведение на западе (центры, кадры, общества) 50 начало 90 гг. в.*, Москва 1997, 270 хуудас.

⁸ Far Eastern Affairs 4-5(1994), 94-118.

⁹ ВКП(б), *Коминтерн и Национально-революционное движение в Китае*, Документы I (1920-1925), Москва 1994, Документы II, 1,2 (1926-1927), Москва 1996.

¹⁰ С. Роцин, *Уполномоченный Коминтерна (Тугар Рыскулов в Монголии)*, Восток 4(1996), 52-61; М. И. Амгаев: *Годы в Монголии*, Восток 6(1997), 43-52-р тал.

¹¹ Г. Адибеков, *Исполком Коминтерна и МНРП*, Научно-информационный Бюллетень, Выпуск №. 8, Москва, 16-25-р тал.

¹² *Элбэг-Доржи Ринчино*, Документы, Статьи, Письмо, Комитет по делам при совете министров Республики Бурятия, Улан-Удэ 1994.

түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой болов уу. Харин Ринчиногийн үйл ажиллагааны үнэлэлт Монголын түүхийн бодит байдалд огт нийцэхгүй байна. Түүнчлэн Роцин 1999 онд "Монголын улс төрийн түүх (1921-1940)" хэмээх ганц сэдэвт бүтээл туурвижээ.¹³ Монгол дахь Коминтерны үйл ажиллагааны талаарх эдгээр баримт бичгийн эмхэтгэлүүд болон бусад бүтээлүүд нь урьд өмнө эрдэм шинжилгээний эргэлтэд хараахан ороогүй, нэн шинэ түүхэнд холбогдолтой баримт бичгүүдийг ашигласан Оросын төвийн хадгаламжинд байсан баримт материалыг задлан шинжилж үзсэнээрээ үнэ цэнэтэй юм.

Ийм учраас тэдгээр нь Монголын түүхийн зарим балархай асуудлуудыг тодруулах цоо шинэ баримт болж өгсөн юм. Тэгэхдээ Коминтерн бол үндсэндээ Оросын Коммунист намын доторх цэвэр улс төрийн байгууллага байсныг сайтар харгалзан үзэлгүйгээр түүхийн тодорхой зурвас үеүдийг тайлбарлах гэсэн зарим нэг оролдлогууд байгаад анхаарал болгоомжтой хандах нь зүйтэй юм.

2. 1911-1924 оны зурвас үеийн Монголын үндэсний төр улсын үүслийн талаарх зарим асуудал

Дорно Дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Белов, Лузянин нар бүтээлүүддээ Монголын үндэсний төр улсын үүслийн асуудлыг авч үзжээ. Ялангуяа 2000 онд хэвлэгдэн гарсан Лузянины "ХХ зууны эхний хагас дахь Орос, Монгол, Хятад. 1911-1946 онууд дахь улс төрийн харилцаа" хэмээх ном сонирхолтой бүтээл болжээ.¹⁴

Лузянин бол оросын монголч эрдэмтдийн шинэ үеийн нэгэн төлөөлөгч бөгөөд уг асуудалд архивын баримт сэлттэй ул суурьтай танилцах замаар нэн зохистой хандсан байна. Тэрээр монголын төр улсын үүслийн асуудлыг орос, зөвлөлт, хятадын харилцааг задлан шинжлэх үүднээс дэлгэн харуулах оролдлого хийжээ. Түүнчлэн тэрээр хэд хэдэн нэн чухал мэдээлэл бүхий бүтээл туурвисан Беловтой хамтран "Восток" сэтгүүлийн 2000 оны № 1-д "БНМАУ-ын түүхэн дахь 'монголын асуудал' гэгч баримтлалын тухайд"¹⁵ гэдэг нэн сонирхолтой өгүүлэл хэвлүүлжээ. Энэ өгүүлэл бол марган хэлэлцүүштэй хэд хэдэн эгзэгтэй асуудлыг агуулсан байна.

3. Орос, Зөвлөлт, Монголын харилцаа

Энэхүү салбар шинжилгээ бол дээр өгүүлсэн хоёрдугаар чиглэлтэй нягт уялдаатай бөгөөд хаант Орос, Монгол хоёрын харилцааны асуудлыг ч бас агуулна. Үүнтэй холбогдуулан 1996 онд Слесарчук-ын ерөнхий удирдлагын дор бүтээгдэн хэвлэгдсэн "Орос, монголын харилцааны түүхэнд холбогдох материал" хэмээх баримт бичгийн эмхэтгэлийн шинэ ботийг энд дурдмаар байна.¹⁶

Түүнчлэн 1994 онд хэвлэгдэн гарсан Даревскаягийн "Сибирь ба Монгол" хэмээх ном чухал нэгэн бүтээл юм.¹⁷ Тус бүтээлдээ тэрээр хуучны мужийн архиваас олж илрүүлсэн олон тооны баримт сэлтийг шүүж үзээд орос, монголын харилцааны тухай тусгай дэлгэрэнгүй бүлэг оруулжээ. Харин Зөвлөлт

¹³ С. Роцин, *Политическая история Монголии 1921-1940*, Москва 1999, 325 хуудас.

¹⁴ С. Г. Лузянин, *Россия-Монголия-Китай в первой половине XX в., Политические взаимоотношения в 1911-1946 гг.*, Москва 2000, 268 хуудас.

¹⁵ Е. А. Белов, С. Г. Лузянин, *О концепции "Монгольского вопроса" в "Истории Монгольской Народной Республики"*, Восток 1(2000), 40-51-р тал.

¹⁶ *Материалы по истории русско-монгольских отношений 1654-1685*. Сборник документов. Составитель Г. И. Слесарчук, Москва 1996.

¹⁷ Е. М. Даревская, *Сибирь и Монголия, Очерки русско-монгольских связей в конце XIX – начале XX веков*, Иркутск 1994.

Орос ба Монгол улсын сүүлийн үеийн харилцааны талаар нийтлэгдсэн зүйлс ховор байгаа юм.

Дурдууштай бөгөөд сонирхол татсан бүтээлүүд гэвэл Надировын "Цэдэнбал ба 1984 он" гэдэг ном, Ганжууровын 1980-1995 оны Орос, монголын харилцааны асуудлаар бичсэн диссертацийн ажил зэрэг болно.

Дурдан буй чиглэлээр нийтлэгдсэн бүтээлүүдийн дотор Агваандоржиев, П.Гэндэн, Барон Унгерн фон Штернберг гэх мэт хүмүүсийн намтарт холбогдох цөөн тооны нийтлэлүүд бий.¹⁸

2001 онд гарсан "Россия и Монголия"¹⁹ гэдэг өгүүллийн эмхэтгэл бол судлаачдын анхаарлыг нэлээд их татсан. Тодорхой архивын баримт бичгүүдийг анх боловсруулсан зарим өгүүллүүд монгол түүхийн үнэн байдлыг сэргээхэд зохистой хувь нэмэр оруулсан. Харин зарим өгүүллийн хувьд зохиогч нь монгол-оросын харилцааны түүхийг Орос улсын өнөөгийн ашиг сонирхлын үүднээс тайлбарлахыг эрмэлзсэн бол түүхч хүний төвийг сахих зарчимд нийцэхгүй юм шиг санагдаж байна.

Япон дахь Монголын түүхийн судалгаа нь түүхийн тодорхой нөхцөл байдалтай уялдан олон жилийн уламжлалыг бий болгосон юм. Гэхдээ судалгааны ажлын гол тусгал өнөө үеийг хүртэл Өвөр Монгол руу гол төлөв чиглэгдсэн байдаг юм. Эндхийн Монголын түүхийн талаарх эрдэм шинжилгээний судалгааг оросын монгол судлалтай жишиж үзэхүл төвлөрсөн хүрээлэнгүүдэд хийгдээгүй олон тооны эрдэм шинжилгээний нэгжүүдээр хийгддэг байна. Гэсэн ч Токуо (гадаад орнуудын судалгааны их сургууль, Ази, Африкийн хэл соёлын хүрээлэн, Тоюо Вунко) болон Осака хотын Гадаад орнуудын судалгааны их сургууль, угсааны үндэсний музейд Монгол судлалын үйл ажиллагаа өргөн хүрээтэй явагддаг.²⁰ Түүнчлэн наяд оноос БНМАУ болон Өвөр Монголд суралцагсдаас төрсөн судлаачид Японы монгол судлалд зонхилох байр суурь эзэлж байгаагаараа онцлог шинжтэй юм.

90-ээд оны эрдэм шинжилгээний нийтлэлүүдийг сөхөж үзэхүл судалгааны гол гол чиглэлүүд ажиглагддаг. Эрдэмтдийн залгамж үеийн халаа нь Монголын түүхийн судалгааны тулгамдсан асуудлыг тогтооход яагаад ингэж нөлөөлж байгаа нь ч гэсэн л сонирхолтой асуудал юм.

1. Ар, Өвөр Монгол дахь Чин Улсын улс төрийн бодлогын судалгаа

Эл судалгаа нь Монгол тэргүүтэй бусад харь угсаатнуудад зориулагдаж байсан Чин улсын хууль эрхэмжийн асуудалд төвлөрч байна. Энэхүү судалгаанд Монгол, Хятадын архивууд дахь хятад, монгол, манж сурвалж хэрэглэгдэхүүнийг өргөн хамруулсан онцлогтой. Хагихара Мамору (Kobe University of Mercantile Marine)²¹ судалгаагаараа юуны өмнө монголд хэрэглэгдэж

¹⁸ В. Е. Раднаев, *Стрихи к портрету Агваана Доржиева (1854-1938)*, Восток 4(1998), 81-92; С. К. Роцин, *Пелжидийн Гэндэн, Монгольский Премьер*, Восток 5(1999), 116-125; Л. Юзефович, *Самодержец пустыни: Феномен судьбы барона Р. Ф. Унгерн-Штернберга*, Москва 1993.

¹⁹ Россия и Монголия, "Новый взгляд на историю взаимоотношений в XX веке", сборник статей, Москва, 2001.

²⁰ Shigeo Ozawa, *Mongolian Studies in Japan, in World Mongol Studies, = Bulletin - The IAMS News Information on Mongol Studies* 1,2(1992), Ulaanbaatar, 93-96-р ман.

²¹ Hagihara Mamoru, *Changes in law in 18th-century Qalq-a Mongolia (18 seiki Haruha-Mongoru ni okeri horitsu no suii)*, in *Toyoshi Kenkyu* 49, 3(1990); *Mongolian law during the Ch'ing dynasty (Shincho no Moko-rei)*, in Shiga Shuzo, *Chinese legal history (Ch ◆ goku h" sei shi)*, T□ ky□ Daigaku Shuppankai 1993; *Mongol law of Qing dynasty and judgment system in Mongolia, 17-19th century*, in *Bulletin of Kobe University of Mercantile Marine* 1(2000).

байсан Чин улсын цааз, тэдгээрийг тусгай тохиолдлуудад хэрэглэдэгдэхүүн болгон эрх зүйн өдөр тутмын практикт хувьсган өөрчилж байсныг харуулсан бол Шимада Масао²² Чин улсын хууль цааз ямар учраас нүүдэлч монголчуудын хувьд үр нөлөөтэй аргачилж чадаж байсан тухай асуудлыг мөшгин сурвалжилжээ.

Түүнчлэн Хироки Ока-гийн Чин гүрэн, Монголчуудын харьцаа, Манж нараас Өвөр ба Ар Монголд байгуулсан засаг захиргааны тогтолцоо зэрэг асуудлаарх судалгаа нэн чухал ач холбогдолтой юм.²³

2. Гадаад Монголын Автономит үеийн судалгаа

Монголын түүхэнд холбогдох архивуудын хэрэглэдэгдэхүүнийг гаргуун сайн мэдэх эрдэмтэн Тацуо Наками хэдийнээс зарим нэг ноёдын үйл ажиллагаа болон Гадаад Монголын Автономит байгуулалтын зүгээс Өвөр Монголд үзүүлж байсан тусгал нөлөөг (feedback) тандаж байсан Оросын дипломат албаны нууц ажиллагаанд холбогдох асуудлыг гол төлөв судалсаар ирсэн билээ.²⁴

Шибуюа Коижи Хиагтын гэрээг хэлэлцэж байх үеийн Хятад, Оросын харилцааны асуудлыг нухацтай авч үзсэн бөгөөд үүндээ Бээжингийн Түүхийн нэгдүгээр архивын Манж хэл дээрх баримт бичгүүдийг Орос хувилбар баримтуудтай нарийвчлан тулган шинжлэх ажлыг хийжээ.²⁵

3. Өвөр Монголын түүхийн судалгаа

Өвөр Монголын түүхийн талаарх судалгаа хоёр бүлэгт хуваагдана:

а. XIX зууны сүүл үеэс XX зууны эхний зурвас үеийн Өвөр Монголын түүхийн судалгаа

б. Дэлхийн II дайны явцад Японоос Өвөр монголд явуулсан цэрэг дайны үйл ажиллагааны судалгаа

а. Бидний гарт байгаа нийтлэлүүдээс үзвэл судлаачид Чин улсын үеийн болон Юань Шикай-ийн үеийн Өвөр Монголын орон нутгийн засаглалын асуудлуудад голлон анхаарсан байна. Янагизава Акира шинэ баргын 8 хошууны зохиосон байгуулалтыг шинжилсэн байхад Киши Тошихико Юань Шикай-ийн засаглалын үеийн Өвөр Монгол дахь орон нутгийн ноёлог ёсны асуудлыг задалж үзсэн байна.

²² Shimada Masao, *Studies in the Effectivity of Ch'ing Mongol laws*, in Monographs on Oriental legal history 7, Sōbunsha 1992.

²³ Hiroki Oka, *The Mongols and the Qing Dynasty*, in *The North Asian Feature of Qing Rule over Mongolia*, Tohoku University 1998, 129-151-р тал; *Чин улсын үеийн монголын засаг хошууны нийгэмийн зохион байгуулалтын тухай шинэ асуудал*, in *The Changing Paradigm of Mongolian Studies - Between Documents and the Field -*, Edited by Konagaya Yuki (=Mongolian Culture Studies II), Köln 2001, 71-97-р тал.

²⁴ Tatsuo Nakami, *Qaisan's secret letters from Urga*, in *Mongolica* Vol. 5(26)1994, 394-398-р тал; *On historical sources relating the diplomacy of the Russian Empire* (Roshia teikoku no gaikō shiryō o megutte), in *Kindai Chugoku* 18(1996); *Babujab and His Uprisings: Re-examining the Inner Mongol Struggle for Independence*, The Toyo Bunko, Tokyo 1999, 137-153-р тал; *Russian Diplomats and Mongol Independence, 1911-1915*, in *Mongolia in the Twentieth Century Landlocked Cosmopolitan*, Ed. by Stephen Kotkin and Bruce A. Elleman, New York, London 1999, 69-78-р тал; *New Trends in the Study of Modern Mongolian History. What Effect have Political and Social Changes Had on Historical Research?*, in *Acta Asiatica*, 76, Tokyo 1999, 7-39-р тал.

²⁵ Shibuya Kōichi, *Russia's Peking caravan trade prior to the Treaty of Kyakhta* (*Kyafuta jō yaku izen no Roshia no Pekin bōeki*), in *Tōkyō Gakuhō* 3-4(1994).

Тецүяама Хироши хятадууд газар нутаг эзэмшиж авсан хийгээд тэдний засаг захиргааны байгууллагуудын сүлжээний тухай нэн эмзэг асуудлыг авч үзжээ.²⁶

б. Сахү Хирокава (Graduate School, Tokyo University of Foreign Studies), Юүничи Ёшида (Waseda-University) нарын судалгаа нь Өвөр Монголд Квантуны армийн явуулсан үйл ажиллагаа болон Японы армийн анги, нэгжүүдээр Өвөр Монголыг сурвалжилж байсан зэрэг асуудлыг дэлгэрэнгүй шинжилсэн байна.²⁷ Японы Монгол судлаачид нилээд хэдэн жилийн өмнөөс халхын голын тулалдааны явц болон ялангуяа уг тулалдааны шууд угтах үеийн түүхийн асуудлыг судалж ирэв. Хироши Футаки, К.Танака²⁸ нарын эл сэдвээрх эрдэм шинжилгээний нийтлэлүүдийн гол цөм асуудал нь оросын эрдэмтэдийн ч судалгаанд²⁹ нэгэн адил үзэгддэг асуудал болох “Аль тал мөргөлдөөнийг даамжруулсан хариуцлагыг хүлээх ёстой вэ?” гэдэгт оршдог юм.

4. Гадаад Монгол, Монгол улс, БНМАУ-ын түүхийг тэдгээрийн өмнөх шаттай нь харьцуулсан судалгаа

Энэ сэдвийн хүрээнд Монголын архивуудаар өргөн хүрээтэй судалгаа хийсэн эрдэмтэн Хироши Футаки Буриад дахь нармай монголын үзэл бодлын асуудлыг задлан шинжилж, үүнтэйгээ сүлбэлдүүлэн Элбэгдорж Ринчиногийн намтрыг авч үзсэн байна. Тэрээр Өвөр Монголтой холбогдуулан БНМАУ-ын төрийн зүтгэлтэн Дамбадоржийн улс төрийн бодлогын талаарх өгүүлэлдээ Монгол ба Орос Хятад дахь харилцаа холбооны асуудлыг үргэлжлүүлэн авч үзсэн байна

БНХАУ дахь Монгол судлал, үндэсний соёлын талаарх төрийн бодлогын тусгал болдог бөгөөд тийм ч учраас үүнийг тодорхой хэмжээгээр дэмжиж байдаг юм. Монгол судлалын ажил нь нийгмийн шинжлэх ухааны академи болон хэд хэдэн их сургуулийн нэгжүүдэд төвлөрч байна.

Монгол судлалын салбарт бусдаасаа тэргүүлэх үүрэг бүхий Бээжин дэх эрдэм шинжилгээний байгууллагуудаас гадна эрдэм шинжилгээний ажлын өндөр чадвар бүхий Өвөр монголын их сургуулийн монгол судлалын хүрээлэн онцгой байр суурь эзэлдэг. Эдгээр байгууллагын эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны асуудлуудын нэг хэсэг нь монголын түүхийн холбогдолтой байна. Тэд судалгааныхаа үр дүнгийн талаар юуны өмнө “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан”, Өвөр монголын их сургууль эрдэм

²⁶ Yanagisawa Akira, *On the establishment of the New Baryu Eight Banners (Shin-Baruga hakki no seiritsu ni tsuite)*, in Shigaku Zasshi 3(1993); Kishi Toshihiko, *The formation of the system of regional rule in Inner Mongolia, under the Yuan Shih-k'ai régime (En Seigai seiken no Uchi-Mongoru chiiki shihai taisei no keisei)*, in Shigaku Kenkyu ◆ 185(1989); Tetsuyama Hiroshi, *The policy of “strengthening the border regions trough migration” in Inner Mongolia in the late Ch’ing (Shinmatsu Uchi-Moko ni okeru “imin jippen” seisaku)*, in Chiiki □□□ Kenkyu ◆ 2(1992), *The commercial-landowner economy of Inner Mongolia during the Ch’ing dynasty*, in T□y□shi Kenkyu ◆ 3(1994).

²⁷ Saho Hirokawa, *Japanese policy toward Inner Mongolia in 1940's and Kōke toyo*, in Bulletin of the Japanese Association of Mongol Studies 28(1997), 29-41-р тал; Junichi Yoshida, *Reports of the Investigation of the Eastern Inner Mongolia by the Army Division of Kantotokuhu*, in Bulletin of the Japanese Association of Mongol Studies 29(1998), 33-44-р тал.

²⁸ Хироши Футаки, *Хурандаа Яногийн үйл амьдрал, үзэл санаа. 1930, 1940-өөд оны үеийн мэдээллийн албаны нэгэн офицерийн үйл ажиллагаа*; К. Танака, *Халхын Голын дайны далд шалтгаан, Халхын Голын дайн: түүхэн үнэний эрэлд*, Улаанбаатар, 1995 он, 39-42-р тал, 89-96-р тал.

²⁹ В. А. Гаврилов, *Халхын Гол: “Инцидент” или фактор большой политики*, Монгол Улсын Аюулгүй байдал: Монгол, Оросын судлаачдын үзэл бодол, Улаанбаатар 1999, 369-377-р тал.

шинжилгээний сэтгүүлээс “гүн ухааны ба нийгмийн шинжлэх ухаан”, “Монгол түүхийн судлал” гэх зэрэг шинжлэх ухааны сэтгүүл, тогтмол хэвлэлүүд дээр нийтлүүлдэг билээ.

Эдгээр нийтлэл Хятад, Монгол хэлээр байх ба үүнд Хятад хэлээрх нь арай давамгай байдаг байв. Харин ерээд оны дундаас эхлэн сэтгүүлийн редакцууд өгүүлэл мэдээллүүдээ бүхэлдээ монголоор нийтлэх болсон.

1990-1995 оны хооронд дээрх сэтгүүлүүдэд монголын түүхийн сэдвээр гагцхүү цөөн тооны өгүүлэл нийтлэгдэж байжээ. Жишээ нь: нэгэн дугаарт дунджаар 13–20 өгүүлэл хэвлэгдэж байхад ердөө л 1-3 нь түүхийн сэдэвтэй байдаг байв. Ихэнх нь хэл шинжлэл, ардын аман зохиол, соёлын сэдвээр нийтлэгддэг байжээ. Түүх судлалын тухайд гэвэл 1990 онд тэмдэглэн өнгөрүүлсэн “Монголын нууц товчоо”-ны 750 жилийн ойтой уялдан уг сурвалж бичиг болон Чингис хааны тусгай судалгаа нилээд өргөн хүрээтэй болсон боловч чухам түүх судлалын асуудал бас л бага, харин монголын их хааны зан үйлийн холбогдолтой асуудал давамгай байв.

“Чингис хааны товчоон” хэмээх 2 боть зохиолоороо алдаршсан судлаач Сайшаал нэгэн өгүүлэлдээ “Нууц товчооны судалгааг тэргүүн зорилт болгох тухай”³⁰ тэмдэглэж байсан ба Р.Түмэн 1991 онд сэтгүүлийн нэгэн дугаараар дамжуулан Шаралдайтай “Чингис хааны судалгааг сэргээх” асуудлаар маргаж байв³¹. Дэвшүүлэн тавьсан эрдэм шинжилгээний тодорхой асуудлаарх хэлэлцүүлэг үндсэндээ бага байлаа. Харин Хөх-Өндөр, Баяннамар нарын нөхөд “Чингис хаан их ор суусан он цагийн асуудал”³²-ыг нягталж үзсэн байх ба Ван Фен Лей, Буян нар Хятад дахь монголын Юан гүрний хяналтын систем, мөнгөн тэмдэгтийн асуудлыг шинжилж үзсэн байна³³.

Сурвалж бичгийн судлалын хувьд судлаачид “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Чандмани Эрих” болон уйгар бичгийн бусад дурсгалуудыг авч үзэж иржээ³⁴.

Байлдагч “Studia Historica Mongolia” цувралын 1989 оны дугаарт нийтлүүлсэн “Монголын атар газар хагалуулсанд ‘иргэн нүүлгэж хязгаар бэхжүүлсэн’ үү?” хэмээх өгүүлэлдээ монголын тал нутагт хятадууд орж нутаглах болсон асуудлаар анх удаа судалгаа хийсэн байна³⁵.

Чимэддорж хэд хэдэн бүтээлдээ “Чин улсад эзлэгдэхийн шууд угтал үеийн монголын түүхэн зурвас үеийн асуудал”-ыг авч үзжээ³⁶. Хүчин “Инжаннашийн бүтээлүүд дэх images болон монгол дахь манжийн албанд

³⁰ Сайшаал, “Монголын нууц товчооны өртөнц дэх анхны явдлууд”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 4-р дэвтэр, 1990 он, 6-23-р тал.

³¹ Р.Түмэн, “Чингисийн тухай судлал сүвэгчлэл”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 6-р дэвтэр, 1991 он, 25-29-р тал.

³² Хөх өндөр, “Тэмүжин Монголын аймгийн хаан болсон он жилийн тухай”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 1-р дэвтэр, 1992 он, 46-50-р тал; Баяннамар, “Чингис хааны хаан сууринд суусан сар өдрийг сүвэгчлэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1993 он, 34-37-р тал.

³³ Буян, “Юань улсын зоосон мөнгөний тухай мөчид өгүүлэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1991 он, 13-24-р тал; Ван Фен Лей, “Юань улсын шалгалтын дүрмийг танилцуулан өгүүлэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1991 он, 39-45-р тал.

³⁴ Сэцэнбилиг, “Хаадын үндэсний хураангуй алтан товчийн зохиогч ба зохиогдсон цагийг тодлох нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 2-р дэвтэр, 1993 он, 25-30-р тал; Хишигтогтох, “Шарын шашны монгол намтар зохиолын чимэг Чандманийн эрих”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 2-р дэвтэр, 1993 он, 77-90-р тал.

³⁵ Байлдагч, “Монголын атар газар хагалуулсанд ‘иргэн нүүлгэж хязгаар бэхжүүлсэн’ үү?”, Studia Historica Mongolica, Хөх хот, 1989 он, 189-197-р тал.

³⁶ Чимэддорж, “Зуунмодын дайны дараах Галдан Бошигт хаан”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1993 он, 98-122-р тал; “Лигдэн хаан нөгчсөний дараа Ар халхын Махасамади сэцэн хаан”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 2-р дэвтэр, 1998 он, 16-25-р тал.

мөрдөж байсан эзэн хааны хяналт шалгалт” гэдэг нэн сонирхолтой өгүүлэл бичсэн байна³⁷. Түүнчлэн Содбилиг “Эзгүй бэлчээр нутагт засгийн газрын цэргийг оруулсан” асуудлаар сурвалж бичиг мөшгөн үзсэн байх ба Хөгжил нь “Чин гүрний хаалттай хаалганы бодлого хийгээд гадаад харилцаа”-ны асуудлыг задлан шинжилсэн байна³⁸.

90-ээд оны II хагасаас Хятадад эрдэм шинжилгээний маргаан хэлэлцүүлэг чөлөөтэй болсонтой уялдан Өвөр монголын Монгол судлаачид урьд үндсэндээ хаагдмал байсан түүхийн сэдвүүдийг хөндөх болжээ.

Алтандалай “1930 оны Монголын гэрээ” бүтээлдээ үнэхээр хүсэн хүлээгдэж байсан нэгэн сэдвийг авч үзжээ³⁹. Буянцогт “Япон хяналтын доорх Монголын тоглоомын засгийн газрын санхүүгийн бодлого” бүтээлдээ Өвөр Монгол дахь Японы түрэмгийллийн асуудлыг анх удаа хөндөн судалсан байна⁴⁰. Мөн Содбилиг “Чин улсын засгийн газраас баруун хойд Хятад дахь Хотон нарын бослогыг дарсан ба Их-Зуу аймаг дахь түүний нөлөө” болон харийн шашны өсөн нэмэгдэж буй нөлөөний эсрэг баруун монголын хошуудын эсэргүүцэл тэмцлийн асуудлаар бичсэн бүтээлүүддээ цоо шинэ асуудлыг хөндөн авч үзжээ⁴¹.

Хурц “Бадагэрмиао хийдийн билчээр ба байгаль орчны хамгаалал” гэдэг өгүүллээрээ Өвөр Монголын түүхийн судлалын хүрээнд шинэ тутам асуудал оруулж ирэв⁴². Вү-фен “Хубилай сэцэн хааны иргэдэд эрх ашиг олгох бодлогын тухай” хэмээх өгүүлэлдээ Күнзийн сургаалийн хүрээний асуудлыг сөхөн тавьжээ⁴³. Өвөр монголын эрдэмтэдийн бусад бүтээлүүд, тухайлбал Өвөр монголын шинэ ардын намын гишүүдийн эсрэг хийгдсэн хэлмэгдүүлэлтийн асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн генерал Түмэнгийн нэг сэдэвт бүтээл ихээхэн ач холбогдолтой юм.

Энэхүү соёлын хувьсгалын хэлмэгдүүлэлтэд 16000-35000 өвөр монгол хүн өртсөн билээ. Түмэн мэт өндөр тушаалтай цэргийн эрхтнүүд уг асуудлыг дэлгэн харуулж байгаа нь өвөр монголын монголч эрдэмтний судалгааг зоригжуулах ач холбогдолтой болсон юм⁴⁴. Түүний 1995 онд Хөх хотод нийтлүүлсэн “Монгол үндэстний дэлгэрэнгүй түүх” хэмээх 3 боть бүтээлд авч үзсэн шиг Монголын түүхэн үйл явдлыг дэлгэрүүлэн судалсан сонирхолтой бүтээлүүд цаашдаа ч гарах нь дамжиггүй⁴⁵.

1996-2001 оны хооронд Өвөр Монголын судлаачид түүхийн төрөл бүрийн ганц сэдэвт бүтээлүүдийг гаргасан. Эдгээр ганц сэдэвт бүтээлүүд дөрвөн чиглэлд хуваагдана.

³⁷ Хүчин, “Инжиннашийн бийрийн эрдэмтэн доорхи мэргэдээс Чин улсын Монголд хэрэгжүүлсэн шалгуулын дүрмийг үзэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 6-р дэвтэр, 1994 он, 104-115-р тал.

³⁸ Хөгжил, “Чин улсын гадаад харилцаа дээрхи түнжмэл бодлогыг өгүүлэх нь”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 4-р дэвтэр, 1994 он, 71-84-р тал.

³⁹ Алтандалай, “1930 оны Монголын хурлын тухай”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 2-р дэвтэр, 1995 он, 44-56-р тал.

⁴⁰ Буянцогт, “Японы эзэрхэг түрэмгийтний эзэмшил доорхи хуурмаг ‘Монгол хязгаарын засгийн газар’-ын мөнгө хүүлээний төрийн бодлого” Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1996 он, 31-52-р тал.

⁴¹ Содбилэг, “Чин улсын засгийн газраас баруун хойдын Хотонгуудын бослогыг даруулсан дайныг Их зуугийн чуулганд үзүүлсэн нөлөө”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 4-р дэвтэр, 1996 он, 90-100-р тал; “1900 онд Монголын баруун хэсгийн монгол хошууд харийн эсрэг эсэргүүцсэн нь”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 3-р дэвтэр, 1998 он, 19-31-р тал.

⁴² Хурц, “Бадгэр сүмийн нутаг билчээр хийгээд орчин тойрны хамгаалалт”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 1-р дэвтэр, 1998 он, 53-65-р тал.

⁴³ Вү Фан, “Хубилай сэцэн хааны иргэдэд эрх ашиг олгох бодлогын тухай”, Өвөр Монголын их сургууль. Эрдэм шинжлэх сэтгүүл. Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, 4-р дэвтэр, 1998 он, 33-39-р тал.

⁴⁴ Түмэн, “Өвөр ардын намын хилс хэрэг”, Хөх хот, Бээжин, 1996 он.

⁴⁵ “Монгол үндэстний нээтэрхий түүх”, I, II, III боть, Бээжин, 1991 он.

1. Өв уламжлалт сурвалж бичгийн судалгааны үргэлжлэл.

Үүнтэй холбогдуулан 1996 онд хэвлэгдсэн Хөх түүх, 1999 онд хэвлэгдсэн Пагва ламын тууж, Хаадын үндэсний хураангуй алтан товч, Чандмань эрихийн судлал, Алтан эрих болон 2000 онд хэвлэгдсэн Арван буянт номын цагаан түүхийг дурдвал зохино.

2. Их Монгол улсын түүхийн судлал

Чойжи багш Их Монгол улсын үеийн Монгол бурханы шашны түүхийг нийтлүүлсэн. Түүний энэ буянт бүтээл бол монголын шашны судалгаанд онцгой хувь нэмэр болсон юм. Одоо Чин улсын үеийн монгол шашны түүх бичих цаг болжээ. Өвөр Монголын түүхчид энэ ажлыг Монгол улсын түүхчидтэй хамт зохиовол зохистой болов уу. Монгол улсад одоо Хархорум нийслэлийн түүхийг дэлгэрэнгүй судалж байна. Энэ үүднээс үзвэл Гүншигийн 1997 болон 2000 онд хэвлүүлсэн Шанду нийслэлийн түүхийн тухай номууд ихээхэн тус нэмэр болж байна.

3. Түүхийн толь зохиох нь

Дамба гуай 2000 онд Монголын үе улирлын бичгийг нийтлүүлсэн. Мөн хамтын бүтээл болох "Монголын түүхийн толь" хэвлэгджээ. Ийм түүхийн толь монгол судлаачдын ажлыг хөнгөвчилж чадна гэж хэн бүхэн ойлгож байна.

4. Өвөр Монголын судлаачид сүүлийн үед намтар судлалыг анхаарч эхэлсэн. Намтар судлал бол түүхийн судалгааны хувьд онцгой байр суурийг эзэлж байна. Хүний намтрыг гүнзгий судалсны үндсэн дээр түүх бичвэл маш өгөөжтэй. Тэгвэл бид түүхийн ар талыг ч гэсэн ойлгоход нэн хялбар. 2000 онд гарсан Нарангуагийн "Асхан жанжны намтар" болон 2001 онд хэвлэгдсэн Алтаншагайн "Хөх Монголын улаан тугчид" хэмээх зохиолууд намтар судлалын эхлэл болсон төдийгүй ХХ зууны үеийн Өвөр Монголын түүхийн судалгааны хоёр томоохон, үнэ цэнэтэй бүтээл болох юм.

Миний бодоход 1995 онд Хөх хотод нийтлэгдсэн "Монгол үндэстний дэлгэрэнгүй түүх" хэмээх гурван боть бүтээл, мөн 1999 онд хэвлэгдсэн шинээр найруулсан "Монгол үндэстний товч түүх" зэрэг бүтээлүүд нь Өвөр Монголын түүхийн судалгааны бодит боломжийг үзүүлж байгаа хэрэг юм.

Ямар ч гэсэн шинэ шинэ сэдэв боловсруулж судлах нь чухал болжээ. Ялангуяа, 20-р зууны үеийн 20-30-аад оны үеийн Өвөр Монгол дахь Коминтерний үйл ажиллагааг судалбал зохилтой. Москва болон Улаанбаатар хотын холбогдох архивууд бүгд нээлттэй байна. Үүнээс гадна энэ сэдэв бол олон улсын хамтын ажиллагаанд боломж нээж өгч байна.

Өвөр Монголын түүхийн судлаачид Монгол, Хятад хэлтэй учраас Юань улсын түүхийн судалгааны хувьд маш давуу талтай юм. Олон улсын хэмжээгээр үзвэл Юань-ши-гийн судалгаа бараг үгүй болжээ. Гэтэл эл судалгаа Монгол судлалд маш чухал байна. Жишээлбэл: Юань-ши-д байгаа намтарын материалд тулгуурлан монгол хэлээр нэг сайн толь хийвэл ихээхэн ач холбогдолтой ажил болно.

Өвөр Монголын түүхчид улиран өнгөрч буй зууны 90-ээд оны хоёрдугаар хагаст дээр дурдсан сэтгүүлүүдэд буддын шашин бүх монголчуудын дунд яаж дэлгэрсэн тухай олон чухал өгүүллийг нийтлүүлсэн⁴⁶. Тэдгээр түүхчид

⁴⁶ Харц. "Хубилай хаан ламын шашныг төрийн шашин болгодгийн учир", Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 6-р дэвтэр, 1996 он, 77-85-р тал; Х.Гуа, "Хубилай хийгээд ламын шашин", Өвөр Монголын үндэсний багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1997 он, 59-р дэвтэр, 13-17-р тал;

уг сэдвийн хувьд анх удаа бүх монголчуудыг хамаарч байгаа судлагдахуун болгож хандсан юм. Тэдний судалгааны хамарсан хүрээ хэмжээ нь их өргөн бөгөөд Тухайлбал, XIII зууны үе буюу улсын багш Пагва ламаас эхлэн XX зууны үе буюу VIII Богд Жавзандамба хутагт хүртэлх цаг үеийг багтаасан гэж хэлж болно.

Олон хүний, олон бүтээлийг задлан ярьж болох боловч Боржигин Хурцын бичсэн “Жавзандамба хутагтын чухал хэрэг явдлын тухай”⁴⁷ гэсэн өгүүлэл нь эрдэм шинжилгээний үнэ цэнээр илүү сонин санагдсанаа тэмдэглэн хэлье.

Энэ дашрамд нэг үг хэлэхгүй бол болохгүй болов уу. Европын монгол судлал өнгөрсөн олон арван жилийн турш алтайн судлалтай холбогдсоор ирсэн тул монгол судлаачид монгол, турк, манж хэлийг голдуу эзэмшиж байна. Хятад хэлтэй монгол судлаачид бараг байдаггүй байна. Тэгвэл БНХАУ-ын монгол судлаачид олон улсын эрдэм шинжилгээний санал шүүмжлэлд оролцохыг хүсвэл монголоор нийтлүүлэх шаардлагатай байна. Үүнээс гадна тэд Оросын Буриад болон Монгол Улсын түүхчдийн хэрэгцээг харгалзаж үзвэл зохилтой. Жишээлбэл: Дэ Вангийн намтарыг монгол хэлэнд орчуулбал зөв байхаа.

Орос, Япон, БНХАУ зэрэгтэй харьцуулахад ерээд оны үеийн баруун европ дахь монголын түүхийн судалгаа төдий их биш байна. Үүний шалтгаан бол монгол судлал тэнд бүхэлдээ удаширсан явдал юм.

Тухайлбал эрдэм шинжилгээний ажилтны орон тоог цомхотгож, монгол судлалд зориулан гаргаж байсан улсын зардал ихэнхдээ шууд хасагдсан юм. Зарим нэг боломжууд утга учиргүй өрсөлдөөн маргаанаас болж алдагдсан нь ч бий.

Хоёр Герман нийлсний дараа монгол судлалын “Их гүрэн” болох боломж байлаа.

Гэтэл одоо Герман улсад Хятад судлал, Төвд судлалын тэнхмийн тоо өсөн нэмэгдсээр байхад монгол судлал ганц ч байхгүй болжээ.

Гэсэн ч монгол судлалыг хадгалан үлдээхэд амин чухал шаардагдах улсын дэмжлэг туслалцаа байхгүйгээр монголын түүхийн судалгааны нийтлэл гарсаар байна.

В. Файт-ийн 1795 оны Илтгэл Шаштир⁴⁸, К. Загастерын⁴⁹ монголын их гүрний нийслэл Хар хорины түүхийн холбогдолтой өгүүллэгүүдийг нэрлэж болох байна. Хар хоринд явуулсан Бонны их сургууль болон Герман Улсын Археологийн Хүрээлэнгийн малтлагийн ажлын үр дүнгийн нийтлэлийг судлаачид тэсэн ядан хүлээж байна.

Берлиний монголч эрдэмтэн У. Б. Баркманн түүнчлэн монголын үндэсний төр улсын үүслийн дотоод урьдчилсан нөхцлийн асуудлыг шинжилсэн “Монголын түүх” (1999 онд), “Гадаад Монгол, БНМАУ дахь газар ашиглалтын

Б.Хичээлт, “Буддын шашин хийгээд монгол хүний нэрийн соёл ‘Монгол хүний төвд нэрийн “Жав” хийгээд “Сүрэн” хэмээхийн учир”, Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 75-82-р тал; Шонхор, “Бурханы шашин монголд дэлгэрсэн тухай товч өгүүлэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан; 1995 он, 4-р дэвтэр, 55-66-р тал; Өлзий, “Нэйж тойны намтар”-ын тухай өгүүлэх нь, Төвийн үндэстний их сургууль, 1996 он, 1-р дэвтэр, 77-85-р тал.

⁴⁷ Боржигин Хурц, “Жавзандамба хутагтын чухал хэрэг явдлын тухай”, Өвөр Монголын үндэстний багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1999 он, 11-24-р тал.

⁴⁸ Veronika Veit, *Die vier Qane von Qalqa. Ein Beitrag zur Kenntnis der politischen Bedeutung der nordmongolischen Aristokratie in den Regierungsperioden K'ang-hsi bis Ch'ien-lung (1661-1796) anhand des biographischen Handbuchs Iledkel Ёastir aus dem Jahre 1795.* Teil I: Untersuchungen, Teil II: Biographien (Iledkel Ёastir Hefte 45-76), = Asiatische Forschungen, Bd. 111, Wiesbaden 1990, 212 (I), 300 (II) хуудас.

⁴⁹ Klaus Sagaster, *Die mongolische Hauptstadt Karakorum*, in Beiträge zur Allgemeinen und Vergleichenden Archäologie 19(1999), 113-126-р тал.

түүхэн нөхцөл” (2000онд), “Монгол-хятадын харилцааны (1952-1996)” зэрэг ганц сэдэвт бүтээлүүдийг туурвижээ.⁵⁰

Ямар ч болов судалгааны ажил бага сага хийгдсээр байна.

Монголын түүхийг аль нэг үзэл бодлоос чөлөөтэй авч үзэхийг эрхэмлэдэг Германы монгол судлал нь монголын түүхийн судалгаанд жинтэй хувь нэмэр оруулсан юм. Германы монгол судлалын эцэг болох эрдэмтэн Вальтер Хейссиг нэгэн бүтээлдээ “Монголчууд–Нэгэн ард түмэн түүхээ сурвалжилж байна” хэмээн нэрлэсэн байдаг. Энэ ном Япон хэлээр хэвлэгдэн гарсан бөгөөд хэдийгээр энэ завсар монголын нийгмийн нөхцөл байдалд зарим нэг өөрчлөлт хувиралт гарсан атугай ч тэр нэгэн асуулт урьд тавигдсаар байна.

Монгол гэдэг нэгэн ард түмэн түүхээ судлан сурвалжилсаар байна.

⁵⁰ Udo B. Barkmann, *Geschichte der Mongolei oder Die “Mongolische Frage” - Die Mongolen auf ihrem Weg zum eigenen Nationalstaat*, Bonn 1999, 422 хуудас; *Landnutzung und historische Rahmenbedingungen in der Äußeren Mongolei, Mongolischen Volksrepublik (1691-1940)- Versuch der Annäherung an ein Thema*, = Senri Ethnological Reports 17, National Museum of Ethnology, Osaka 2000, 173 хуудас; *Die mongolisch-chinesischen Beziehungen (1955-1996) - eine Anamnese*, = Mitteilungen des Institutes für Asienkunde Hamburg, Bd. 338, Hamburg 2001, 180 хуудас.